

# КОВИД-19 ХАДВАРЫН ТАРХАЛТЫГ УДААШРУУЛАЯ

## Арлингтонд КОВИД-19 халдварын шинжилгээ өгч болно

### 1 ШИНЖ ТЭМДЭГТЭЙ ЭСЭХ

КОВИД-19 халдварын хамгийн түгээмэл шинж тэмдгүүд бол 38 хэмээс дээш халуурах, ханиах, амьсгаадах буюу амьсгал хүндрэлтэй болох зэрэг юм. Мөн бие арзайх, чичрүүлэх, булчин өвдөх, толгой өвдөх, хоолой өвдөх, амтлахуй үнэрлэхүй алдагдах зэрэг бусад шинж тэмдэг илэрч болно. Амьсгал саатах, цээж хөндүүрлэх, ухаан санаа балартах, босч чадахгүй болох, уруул нүүр хөхрөх зэрэг аюултай шинж тэмдэг илэрсэн бол 911 руу залгана уу. Аюултай биш ч шинж тэмдэг илэрсэн хүн бүр, ялангуяа 65-аас дээш насны, жирэмсэн, чихрийн шижинтэй эсхүл өөр шалтгаанаар өндөр эрсдэлт бүлэгт багтах бол 2-р алхмыг гүйцэтгэнэ үү.

Ихэнх хүмүүсийн хувьд КОВИД-19 халдвар авсан ч гэрийн нөхцөлд аяндаа эдгэрдэг. Та КОВИД-19 халдвар авсан болох нь тогтоогдсон эсхүл шинжилгээ өгөөгүй ч амьсгалын замын өвчний шинж тэмдэг илэрсэн бол гэрээс гарахгүй байх, бусадтай харьцах тохиолдолд амны хаалт зүүх, гараа ойр ойрхон угаах, эд юмсын гадаргуйг тогтмол ариутгах, мөн өвчтэй байгаагаа ойрын хүмүүстээ мэдэгдэх хэрэгтэй.

### 2 ЭХЛЭЭД УТАСД

Та өөрийн эмчгүй эсхүл даатгалгүй бол энэ хуудсанд дурдсан эмнэлгүүдийн аль нэг рүү залгана уу. Эмч буюу эмнэлгийн зүгээс танд үзлэгийн цаг өгөх ба үзлэгийг биечлэн очих байдлаар эсхүл онлайн гүйцэтгэх боломжтой. Бусдын эрүүл мэндийг хамгаалах үүднээс эмч рүүгээ эсхүл эмнэлэг рүү явахаас өмнө урьдчилан утасдаж мэдэгдээрэй.

### 3 УРЬДЧИЛСАН ШАЛГАЛТ

Таныг онлайн шалгаж үзэхэд шинжилгээ өгөх шаардлагатай гэж гарсан бол эмч эсхүл эмнэлэг танд үзлэгийн цаг өгөх юмуу шинжилгээний газар руу илгээнэ.

Та биечлэн очиж үзүүлэхэд эмч таныг шинжилгээ өгөх шаардлагатай гэж үзсэн, мөн эмч эсхүл эмнэлэг шинжилгээ авах боломжтой бол танаас шинжилгээний сорьц авах юмуу шинжилгээний газар руу илгээнэ. Эмч таныг үзээд КОВИД-19 халдварын шинж тэмдэггүй гэж үзсэн бол эмчийнхээ зааврыг дагана уу.

[www.arlingtonva.us/covid-19](http://www.arlingtonva.us/covid-19)

КОВИД-19 халдварын талаар асуух зүйл гарвал КОВИД-19-ийн  
703-228-7999 дотно утсанд залгана уу  
Баасан-Даваа 7:00 – 21:00; Бямба 9:00-17:00

Фейрфакс хотын Эрүүл мэндийн газраас авсан мэдээллийг шинэчлэн өөрчлөв

Халдварт өвчний судлалын төв дараах тохиолдолд КОВИД-19 халдварын шинжилгээ өгөхийг зөвлөж байна. Үүнд: эмнэлэгт хэвтэж эмчлүүлж буй өвчтнүүд, шинж тэмдэг илэрсэн эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд, шинж тэмдэг илэрсэн асрамж эсхүл өөр төрлийн олноор амьдардаг газрын оршин суугчид, КОВИД-19 халдварын шинж тэмдэг илэрсэн хувь хүмүүс эсхүл шинж тэмдэг илрээгүй ч нийгмийн эрүүл мэндийн хяналт, тандалтын зорилгоор эмч илгээсэн тохиолдол. Зарим шинжилгээний газар урьдчилсан байдлаар шалгуулах, эмчийн бичиг авчрахыг шаардаж болохоос гадна ихэнх газар цаг авахыг шаардана.

### 4 ШИНЖИЛГЭЭ

КОВИД-19 халдварыг тогтоох шилдэг сорил бол хамар эсхүл амны арчдас юм. Нүдний шил, амны хаалт эсхүл респиратор, нөмрөг болон бээлий зэрэг хувийн хамгаалалтын өмсгөлтэй эрүүл мэндийн ажилтан танаас сорьц авна. Авсан сорьцыг лацдаж, лабораторит шинжлүүлэхээр илгээнэ.

### 5 ХАРИУ АВАХ

Шинжилгээний хариу гарсан болохыг танд мэдэгдэнэ. Шинжилгээний хариу хүлээж байх хугацаанд бусдаас тусгаарлагдан гэртээ байх, нийгмийн зай баримтлах боломжгүй бол амны хаалт зүүх явдал чухал юм. Танд КОВИД-19 халдвар илэрсэн бол өөрийгөө болон бусдыг хэрхэн хамгаалах талаар танд зөвлөгөө өгч, таны хавьтлуудыг тогтоох болно.

# Арлингтон мужийн КОВИД-19 (вирусийн) халдварын шинжилгээний газрууд

Арлингтон мужийн КОВИД-19 халдварын шинжилгээ өгч болох газруудын байрлалыг доор жагсаав. Оношилгооны зорилготой шинжилгээгээр вирусийн зарим хэсгүүдийг илрүүлж, халдвар тээж байгаа эсэхийг тогтоох боломжтой. Хамрын хөндийн араас, амнаас болон амьсгалын доод замаас арчдас авч шинжилгээнд ашиглана.

Эмнэлгийн нэр, хаяг	Утасны дугаар, цахим хуудас, ажиллах цагийн хуваарь	Даатгалгүй өвчтөн хүлээж авах эсэх	Цаг авах шаардлагатай эсэх	КОВИД-19 халдвар илрүүлэх үйлчилгээ	КОВИД-19 халдварын шинжилгээ	Төлбөр (даатгалаар төлөгдөх эсхүл төлөгдөхгүй байж болно)
<b>ШИНЖИЛГЭЭ ӨГӨХ ГАЗРЫН БАЙРЛАЛ, ЭМНЭЛГИЙН НЭР</b>						
<b>Commonwealth Medical Center</b> 3535 S. Ball St., Ste. A Arlington, VA 22202	571-260-0069 <a href="http://www.commonwealthmc.net">www.commonwealthmc.net</a> Даваа-Баасан: 9:00-16:00	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үзлэг: \$150 Шинжилгээ: \$50
<b>INOVA Urgent Care – North Arlington</b> 4600 Lee Hwy Arlington, VA 22207	571-492-3080 <a href="http://www.inova.org/locations/inova-urgent-care-north-arlington">www.inova.org/locations/inova-urgent-care-north-arlington</a> Даваа-Баасан: 8:00-20:00	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үзлэг: \$50 Үнэлгээ: \$200 (шаардлагатай бол)
<b>Urgent Care Center of Arlington</b> 2439 N. Harrison St. Arlington, VA 22207	571-210-3161 <a href="http://www.urgentcarearlingtonva.com">www.urgentcarearlingtonva.com</a> Даваа-Баасан: 8:00-21:00 Бямба/Ням: 8:00-18:00	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Үзлэг: \$150 Шинжилгээ: \$50
<b>ЗӨВХӨН ШИНЖИЛГЭЭ ӨГӨХ ГАЗРЫН БАЙРЛАЛ</b>						
<b>COVID-19 Drive-Through Collection Site</b> (Arlington County/Quest) 1429 N. Quincy St. Arlington, VA 22207	<a href="http://health.arlingtonva.us/covid-19-coronavirus-updates/covid-19-testing">health.arlingtonva.us/covid-19-coronavirus-updates/covid-19-testing</a> Даваа-Баасан: 9:00-16:00	Үгүй	Үгүй	Үгүй Гэхдээ эмчийн бичиг шаардлагатай	Тийм	Quest төлбөрийн даатгал (эрүүл мэндийн даатгал хэрэгтэй)
<b>COVID-19 Walk-Up Collection Site*</b> (Арлингтоны төлбөргүй эмнэлэг болон Арлингтоны гүнлэг, Виржиниагийн Эрүүл мэндийн газар зэрэг байгууллагын түншлэл) <b>Arlington Mill Community Center</b> 909 S. Dinwiddie St. Arlington, VA 22204	703-912-0118 <a href="http://health.arlingtonva.us/covid-19-coronavirus-updates/covid-19-testing">health.arlingtonva.us/covid-19-coronavirus-updates/covid-19-testing</a> Даваа-Баасан: 13:00-17:00	Тийм	Тийм	Тийм	Тийм	Төлбөргүй
<b>Preston's Pharmacy</b> 5101 Lee Hwy Arlington, VA 22207	703-522-3412 <a href="http://www.prestonspharmacy.com">www.prestonspharmacy.com</a> Даваа-Баасан: 6:00–18:00	Тийм	Тийм	Тийм	Тийм	Эмийн сангийн хураамж: \$35

\* КОВИД-19 Walk-Up шинжилгээний газар нь Арлингтон мужид оршин суугаа 13 болон түүнээс дээш наасны, орлого багатай, даатгалгүй эсхүл даатгал хангалтгүй иргэдийг шинжилгээ өгөх боломжоор хангах зорилготой Арлингтоны аюулгүй байдлын сүлжээний төлбөргүй эмнэлгийн удирдлаган доор үйл ажиллагаа явуулдаг болно.